



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын  
худалдаагаар худалдах зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа Говь-Алтай аймаг дахь Анагаах ухааны их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны үнээ нөхсөн нийт 17,470,000.00 (арван долоон сая дөрвөн зуун далан мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа Говь-Алтай аймаг дахь Анагаах ухааны их сургуулийн захирал М.Банзаагаяад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу тухайн байгууллагын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.5. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

0000011

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2020 оны 08 дүгээр сарын 31-ны өдрийн  
 103 дугаар тогтоолын хавсралт

**АШУИС-ИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ САЛБАР АНАГААХ УХААНЫ СУРГУУЛИЙН  
 ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДАХ АВТОМАШИН**

д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	Мицубуши Пажеро ГАУ-50-54, арал-V464211875	1996/2005	248381	17,470,000	17,470,000	0	-	700,000.00
	<b>Нийт дүн</b>			<b>17,470,000.00</b>	<b>17,470,000.00</b>			<b>700,000.00</b>
				(арван долоон сая дөрвөн зуун далан мянга)				(Долоон зуу)